МЭДЭЭ · 2021 оны 4-р сарын 30

ХҮҮХДИЙГ ЗОДОЖ ШИЙТГЭХИЙН ЭСРЭГ ОЛОН УЛСЫН ӨДӨР



Жил бүрийн 4 дүгээр сарын 30-ны өдөр бол "Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг Олон улсын өдөр". Хүүхдийн бие махбод, сэтгэл санааны шийтгэлийг таслан зогсоохын чухлыг олон нийтэд сануулах энэ өдрийг дэлхий дахинд 2001 оноос хойш, манай улсад 2006 оноос хойш тэмдэглэж иржээ. Энэ өдөр хүүхдийг зодож шийтгэхийг таслан зогсооход чиглэсэн нөлөөллийн ажлууд зохион байгуулж, хүүхэд хүмүүжүүлэх эрэг аргуудыг эрэлхийлэхийг эцэг эх, асран хамгаалагч нарт уриалж сануулж ирсэн байна.

Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүүхдийн эрхийн тухай конвенцод Монгол Улс 1990 оны 7 дугаар сарын 05-ны өдөр нэгдэн орсноос эхлэн Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж ирсэн.

Энэхүү конвенцод "Оролцогч улсууд хүүхдийг, түүний эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч болон гэр бүлийн бусад гишүүний байдал, үйл ажиллагаа, үзэл бодол болон итгэл үнэмшлийг үндэслэн аливаа хэлбэрээр алагчлахгүй бөгөөд шийтгэхээс хамгаалах бүх зохистой арга хэмжээг авна." гэж заасан байдаг бөгөөд Монгол Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулиудад энэ талаар хуульчилсан байдаг.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 2 дугаар сарын 05-ны өдөр Улаанбаатар хот

ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬ

7 дугаар зүйл. Хүүхдийн хамгаалуулах эрх

7.1. Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодийн шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй.





www.prokuror.mn

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 2 дугаар сарын 05-ны өдөр Улаанбаатар хот

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

2 дугаар зүйл. Хүүхэд хамгаалллын зарчим, тогтолцоо

2.6. Хүүхэд, өсвөр насны хүнийг халамжлах, эмчлэх, удирдан чиглүүлэх, тэдэнд боловсрол олгох үүрэг хүлээсэн эцэг, эх, асран хамгаалагч, бусад хүн тэднийг хүмүүжүүлэх, алдаатай зан авирыг нь засахдаа бие махбодийн болон доромжлон гутаасан бүх төрлийн шийтгэлийн арга хэрэглэхийг хориглоно.

5 дугаар зүйл. Гэр бүл дэх хүүхэд хамгаалал

5.4. Эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, хамаатан садан, багш сурган хүмүүжүүлэгч нь хүүхдийг өсгөн хүмүүжүүлэх, боловсрол олгох, асран хамгаалахдаа хүчирхийллээс ангид хүмүүжлийн арга хэрэглэнэ.

www.prokuror.mn

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 5 дугаар сарын 11-ны өдөр Улаанбаатар хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

6.20 дугаар зүйл. Хүүхдийн эрхийг зөрчих

7. Хүүхдийн бие махбодод халдсан, эсхүл үл хайхарсан, эсхүл хүүхдийн дэргэд архидан согтуурсан, мансуурсан, хүчирхийлэл үйлдсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол ХҮНИЙГ 300.000 ТӨГРӨГӨӨР ТОРГОНО.





www.prokuror.mn

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Улаанбаатар хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

16.7 дугаар зүйл. Хүүхэдтэй хэрцгий харьцах

1. Арван найман насанд хүрсэн хүн хүүхдийг аливаа үйлдэл, эс үйлдэхүйн төлөө удаа дараа хэрцгий харьцаж, бие махбодын, сэтгэл санааны шаналал, зовиур үүсгэсэн бол 450.000- 1.350.000 ТӨГРӨГӨӨР ТОРГОХ, ЭСХҮЛ 240-720 ЦАГ ХҮРТЭЛ ХУГАЦААГААР НИЙТЭД ТУСТАЙ АЖИЛ ХИЙЛГЭХ, ЭСХҮЛ 1-3 САР ХҮРТЭЛ ХУГАЦААГААР ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛ ШИЙТГЭНЭ.

2. Энэ гэмт хэргийг багш, сурган хүмүүжүүлэгч, асран хамгаалах үүрэг хүлээсэн хүн үйлдсэн бол 450.000-2.700.00 ТӨГРӨГӨӨР ТОРГОХ, ЭСХҮЛ 240-720 ЦАГ ХҮРТЭЛ ХУГАЦААГААР НИЙТЭД ТУСТАЙ АЖИЛ ХИЙЛГЭХ, 1-6 САР ХҮРТЭЛ ХУГАЦААГААР ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛ ШИЙТГЭНЭ.

www.prokuror.mn

Энэ оны 1 дүгээр улирлын байдлаар дээрх төрлийн гэмт хэрэг, зөрчлийн гаралт улсын хэмжээнд дараах байдалтай байна.

Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасан зөрчлийн хэрэг 2020 онд 2611 бүртгэгдсэн бол 2021 оны 1 дүгээр улиралд 1139 бүртгэгдэж шалгагдсан байна.

Харин Эрүүгийн хуулийн тусгай ангийн 16.7 дугаар зүйлд заасан Хүүхэдтэй хэрцгий харьцах гэмт хэрэг өмнөх оны мөн үетэй ижил түвшинд буюу нийслэлд 2, орон нутагт

1, нийт 3 гарсан байна. Үүнээс 1 хэргийг прокурор яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлж шийдвэрлэжээ.

ХҮҮХДЭЭ ЭРЭГ АРГААР ХҮМҮҮЖҮҮЛЬЕ!

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2876